




Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ
ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБОО



"БИЗНЕСЭЭ АЛБАН ЁСООР ЭРХЭЛЬЕ" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН
АВЛАГА


Улаанбаатар хот
2024 он



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ
ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБОО



"БИЗНЕСЭЭ АЛБАН ЁСООР ЭРХЭЛЬЕ" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2024 он

► Агуулга

ТАНИЛЦУУЛГА	3
НАСАНД ХҮРЭГЧДИЙН БОЛОВСРОЛД АНХААРАХ ЗҮЙЛС	5
Сургалтын зорилго	7
Сургалтаас хүлээгдэж буй үр дүн	7
Сургалтын үндсэн хэсэг	7
ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	8
ХИЧЭЭЛ I: ТАНИЛЦУУЛГА	13
ХИЧЭЭЛ II: БИЗНЕСИЙГ АЛБАЖУУЛАХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	14
Сэдэв 1: Бизнесээ албажуулах гэж юу гэсэн үг вэ?	14
Сэдэв 2: Бизнесээ албажуулах нь яагаад чухал вэ?	16
Сэдэв 3: Бизнесээ албажуулахад тулгардаг сорилтууд	17
ХИЧЭЭЛ III: АЛБАЖУУЛАХ ҮЙЛ ЯВЦ	19
Сэдэв 1: Бизнесээ бүртгүүлэх нь	19
Сэдэв 2: Нягтлан бодох бүртгэлийн систем	21
Сэдэв 3: Татварын бүртгэл	23
Сэдэв 4: Бизнесээ албажуулах үйл явцад хамаарах нийгмийн хамгааллын асуудал	25
Сэдэв 5: Албажуулах үйл явцад хамаарах хөдөлмөрийн харилцаа, зохистой хөдөлмөр	27
Сэдэв 6: Анхаарах тусгай шаардлагууд	29
ХАВСРАЛТ: ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС	31

► ТАНИЛЦУУЛГА

Бизнесээ албан ёсоор эрхэлье сургалтын модуль нь албан бус эдийн засагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг албан салбарт шилжүүлэхэд туслах зорилготой.

Энэхүү сургалтын модулийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан Бизнесээ илүү сайн удирд (GERME) сургалтын хөтөлбөрийн нэмэлт байдлаар боловсруулсан. Модулийн зорилго нь бизнесээ албажуулахын ач холбогдол, албажуулах алхмууд, бичил болон жижиг аж ахуйн нэгжийг албажуулахад тулгарах бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаарх мэдлэг, ойлголтыг эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгоход оршино¹.

Түүнчлэн сургалтаар албан ёсоор бизнес эрхлэхэд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг ямар учраас, хэрхэн дагаж мөрдөх талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлнэ.

Энэхүү сургалт нь **Сургагч багшийн гарын авлага, Суралцагчийн гарын авлага** гэсэн хоёр гарын авлагатай. Суралцагчийн гарын авлага нь үндсэн гурван бүлэгтэй.

Хоёрдугаар бүлэгт суралцагчдад ойлгоход дөхөм болгох үүднээс сэдэвтэй холбоотой олон талын мэдээллийг агуулсан. Тус бүлэг нь хоёр хэсэгт хуваагдана.

1-р хэсэг «Албан ёсоор бизнес эрхлэх тухай ерөнхий ойлголт». Энэхүү хэсэг нь бизнесийг албажуулах гэж юу болох (албан ёсны бизнес эхлүүлэх эсвэл одоо байгаа бизнесээ албажуулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, захиргааны үе шатууд)-ыг ойлгоход туслах, бичил эсвэл жижиг бизнесийг албажуулах шаардлага, үндэслэл, мөн албажуулах явцад эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчдэд даван туулах шаардлагатай зарим үндсэн сорилтуудыг тайлбарлах болно.

Гарын авлагын «Бизнесээ албан ёсоор эрхлэх үйл явц» нэртэй 2-р хэсэгт эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчид эрхэлж буй үйл ажиллагааныхаа онцлогтой холбоотой тодорхой шаардлагуудыг хангахын тулд албан ёсны бүртгэл хийлгэж гэрчилгээ авахаас эхлээд бизнесээ албажуулах үйл явцын бүхий л алхмуудыг багтаасан болно. Сургалтын энэ хэсгийг 4 үндсэн сэдвийн доор зохион байгуулна.

- i) «Би юуг ойлгох ёстой вэ» сэдвийн дор албажуулах үйл явцын ерөнхий мэдээллийг өгнө.
- ii) “Монгол улсад хэрхэн хэрэгждэг вэ” сэдвийн дор Монгол улсад албажуулах үйл явцыг хэрхэн, хаана, ямар нөхцөлөөр хэрэгжүүлэх талаарх бүхий л үндсэн мэдээллийг бизнес эрхлэгчдэд олгоно.
- iii) “Би юу хийх ёстой вэ» хэсэгт туршлагатай бизнес эрхлэгчдийн өгсөн санал, зөвлөмжийг багтаасан.
- iv) «Зарим хэрэгтэй хаягууд» хэсэгт бизнес эрхлэгчид нэмэлт мэдээлэл авах эсвэл албажуулах үйл явцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууллагуудын цахим хаягийг оруулсан болно.

Гарын авлагын **Гуравдугаар бүлэгт** суралцагчид олж авсан мэдлэгээ шат дараатай хэрэгжүүлэхэд чиглэсэн суралцах үйл ажиллагааг дэмжих дасгал ажлуудыг багтаасан. Тиймээс энэ бүлэгт суралцагчид сургалтын явцад эзэмшсэн мэдлэг, бизнесээ албажуулах чадвараа үнэлээд зогсохгүй, холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой түвшингээ тодорхойлох боломжийг олгодог ганцаарчилсан болон бүлгийн дасгал ажил, өөрийн үнэлгээний хүснэгтийг багтаасан.

Мөн энэ бүлэгт бизнес эрхлэгчдэд албан бусаас албан хэлбэрт шилжих үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг болох хүснэгтийг багтаасан болно.

Гарын авлагын **“Хавсралт”** хэсэгт өмнө нь хэлэлцсэн асуудлуудтай холбоотой суралцагчийн ойлголтыг бэхжүүлэхэд туслах нэмэлт мэдээлэл бүхий хавсралтуудыг оруулсан.

¹ Энэхүү сургалт нь дараах гурван шалгуурыг хангасан бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд зориулагдсан болно: i) бичил болон жижиг бизнесийн эзэн, менежер байх, эсвэл бизнес эрхлэх туршлагатай, хүсэл тэмүүлэлтэй аж ахуй эрхлэгч байх (жишээ нь, TRIE-CREE сургалтын хөтөлбөрт хамрагдсан); ii) албан ёсны хэлээр уншиж, бичих чадвартай байх, сургалтад хамрагдах, сургалтын дараах үйл ажиллагаанд оролцох боломжтой байх.

Хэдийгээр энэхүү сургалтын модулийг бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс бие даан ашиглах боломжтой байдлаар боловсруулсан боловч илүү үр дүнтэй болгох үүднээс суралцагчдад тухайн сэдвээр анхан шатны сургалт өгөхийг зөвлөж байна. Сургалтыг бизнес хөгжлийн төвүүд, жижиг дунд үйлдвэрийн агентлаг, тэдгээрийн сургалтын алба, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо, ажил олгогч, бизнесийн байгууллагууд зохион байгуулж болно. Энэхүү сургалтыг бизнесийн сургалтын сертификаттай сургагч багш нар, бизнес, аж ахуй эрхлэх сургалт явуулах туршлагатай бие даасан зөвлөхүүд болон зөвлөх компаниуд зохион байгуулж болно.

Бизнес эрхлэгчдэд энэ сэдвээр мэдээлэл хангалттай өгснөөр тэднийг энэ чиглэлийн мэргэжилтэн болгон бэлтгэсэн гэж ойлгож болохгүй. Шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, шаардлагуудыг хангахын тулд мэргэшсэн хүмүүс эсвэл байгууллагуудад хандах шаардлагатай болдог.

Гарын авлагын зорилго

Энэхүү гарын авлага нь “Бизнесээ албан ёсоор эрхэлье” сургалтыг удирдан явуулах сургагч багш нарт зориулагдсан болно.

Гарын авлагын зорилго нь сургагч багш нарт тухайн сэдвээр сургалтыг цэгцтэй, амжилттай зохион байгуулж явуулахад туслах юм. Хичээлийн төлөвлөгөөг дэд сэдвүүдээр гаргаж, хичээлийн зорилгыг тодорхой тусгах, үйл ажиллагаа тус бүрийг хэрхэн явуулах талаар дэлгэрэнгүй тайлбарлах болно. Тус сургалт нь суралцагчдад “мэдлэг олгох” аль эсвэл албажуулах явцад мэргэжилтэн болгох зорилго агуулаагүй бөгөөд **харин тэднийг аль болох хэрэгцээтэй мэдээллээр хангах, тэр тусмаа бизнесээ албажуулах санааг хэрэгжүүлэх урам зориг өгөх**, улмаар санаачлагаа итгэлтэй гаргаж, хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилготой. Мөн бизнес эрхлэгчид эсвэл бизнес эрхлэх хүсэлтэй хүмүүст бизнесээ албажуулах явцыг үнэлэх, төлөвлөх чадварыг эзэмшүүлнэ.

Хичээл бүрийг суралцагчийн түвшинд «тохируулж», тэдний хүлээлтэд хамгийн ихээр нийцүүлэх нь чухал юм. Үндсэндээ сургалт 3 хагас өдөр, өдөрт 5 цагаар, нийт 15 цаг үргэлжилнэ. Гэхдээ албажуулах ажлын явцаас хамааран зарим суралцагчийн хувьд албажуулах үйл ажиллагаагаа зөв эхлүүлэхэд бэлтгэх ажилд хугацаа бага шаардагдаж болно.

Хэрэв таны сургалтад бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамрагдах бол бизнес эрхлэгчийн өнцгөөс сургалтад хамрагдаж бизнесээ албажуулах явцад тулгарч болох бэрхшээлүүдийн талаар тэднээс санаа зоволгүй асуугаарай. Ингэснээр тэдэнд бизнесээ албажуулах үйл явцад нь илүү үр дүнтэй дэмжлэг болох юм.

Сургалтыг зохион байгуулахдаа цагийн хуваарь болон сургалтын байрыг оролцогчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэх, ялангуяа хөдөлгөөнд чөлөөтэй байх, мөн гэрийн болон асран халамжлах үүрэг хариуцлагатай нь холбоотойгоор цаг хугацааны боломж зэргийг харгалзаж үзэхийг зөвлөж байна. Төвлөрсөн байршилд, гэрэлтүүлэг сайтай, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт бүх хүнд хүртээмжтэй ариун цэврийн өрөөтэй, өдөр өнжүүлэх, шаардлагатай бол хүүхэд хөхүүлэх өрөөтэй байх зэрэг нь чухал юм.

Бодит үр дүнг хүлээж байдаг аливаа сургалтын нэгэн адил суралцагчдад сургалтын дараах тусламж, дэмжлэг үзүүлэхийг сургагч багш нарт зөвлөдөг. Ингэхдээ бизнес эрхлэгч эмэгтэйчүүд зэрэг хамгийн эмзэг бүлгүүд, ялангуяа тэдэнд тулгарч буй бэрхшээлүүдэд анхаарал хандуулах хэрэгтэй. Түүнчлэн сургагч багш нар суралцагчийн урам зоригийг мохоох аливаа эрсдэлийг тооцоолж, суралцагчдад 3 сарын хугацаанд дор хаяж 6 цагийн ганцаарчилсан зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо

📍 Union building оффис Б корпус 1505
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот 14230, Монгол улс

☎ 976 1325635

🌐 www.monef.mn

✉ monef@monef.mn



"Харшпресс" ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-0-3830-4